



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/144

Арвайхээр

Г Комисс томилох, үнэ тогтоох тухай Г

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9.1, 9.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар багийн Дөл хороололд худалдаа үйлчилгээний зориулалттай 2 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга: Ц.Хашхүү -аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Дуудлага худалдааны хөтлөгч: Э.Хорлоо -аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Тэмдэглэл хөтлөгч: Г. Дуламдорж -аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Гишүүд: С.Ганчимэг –аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Газар, байгаль орчин, аялал жуулчлалын бодлого төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн

Г.Ариунаа –аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны өсгөн хэлэх үнийн доод хязгаарыг 100,000 (нэг зуун мянга) төгрөг, дээд хязгаарыг 500,000 (таван зуун мянга) төгрөг байхаар тогтоон, зохих журмын дагуу дуудлага худалдааг зохион байгуулахыг комиссын дарга (Ц.Хашхүү)-д үүрэг болгосугай.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллахыг комиссын дарга (Ц.Хашхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011100311